

**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ЭБАТ-НЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**


2025 оны 06 дугаар сарын 10

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2025 онд Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 3 зорилт 24 арга хэмжээтэй нэгдсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхний хагас жилийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар болон 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодын ХАСХОМ-ын 2024 оны мэдүүлгийг шинэчлэн гаргах 41 албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлгийг гаргуулж, баталгаажуулан Биеийн тамир, спортын Улсын хороонд 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 2/72 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр ССАЖЗЯам, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас албан хаагчдад зориулан зохион байгуулсан 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг хамруулсан.

Авлигатай тэмцэх газраас 2025 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга хамрагдан суралцаж сургагч багшийн гэрчилгээ эзэмшиж нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, албан хаагчдад 1 удаагийн сургалт зохион байгууллаа.



Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудасанд 11 сошиал сувгуудад 12, дотоод сүлжээнд 12-ыг 7 хоног тус бүр байршуулж, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын пэйж хуудас болон албан хаагчид тус бүр өөрийн фэйсбүүк, твиттерт байршуулж иргэд олон нийтэд түгээж ажилласан. Мөн ажлын байранд авлигын эсрэг мэдээллийн самбар 1, авлигын эсрэг зурагт хуудсыг 11, албан хаагчдын өрөөний хаалга, компьютер зэрэгт авлигын эсрэг сурталчилгааны наалт 11-ыг тус тус байршуулж мэдээллээр хангаж ажиллаа.

эсрэг зурагт хуудсыг 11, албан хаагчдын өрөөний хаалга, компьютер зэрэгт авлигын эсрэг сурталчилгааны наалт 11-ыг тус тус байршуулж мэдээллээр хангаж ажиллаа.



Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу байгууллагын албан ёсны цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг ил тод нээлттэй мэдээлж хэвшсэн бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар зохион байгуулсан биеийн тамир, спортын 30-н ажил, үйлчилгээний 50 мэдээг sport.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж 3753 хүнд, "Нийслэлийн Биеийн тамир, спортын газар" пэйж хуудсанд 326 нийтлэл байршуулж, 1,989,928 удаа хүргэж, 24779 удаа шэйр хийж, 80 рийлсийг 1,239,494 удаа үзэж, 56 зүйлийн 2820 зураг байршуулж 3,415,697 удаа үзсэн байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг 735 удаа хувь хүн, байгууллагатай цахим шуудангаар мэдээ, мэдээлэл солилцсон.

Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагаас зохион байгуулах үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байх зорилгоор Авлигын эсрэг "МЭДЬЕ, НЭГДЬЕ" аянд нэгдэж Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем erp.ulaanbaatar.mn болон байгууллагын цахим хуудсанд байгууллагын албан хаагчдыг оролцуулсан 1 минутын бичлэгийн сурталчилгааг хийж орууллаа.



2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтийн үйл ажиллагааны үеэр авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, сурталчилгааны ваннер, хулдаасан хэвлэл, асар майхан тохижуулж, авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор олны танил гүйгчид 00110 энгэрийн дугаарыг олгож ард иргэдэд сурталчилсан бөгөөд Нийслэлийн нутгийн захиргааны 87 байгууллагын 1512 албан хаагч, есөн дүүргийн хэлтэс, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжийн нийт 463 байгууллагын 8912 ажилтан албан хаагч болон нийт 30 мянга гаруй иргэдэд мэдээ мэдээлэл, сурталчилгааг хүргэж ажилласан.



2025 оны 12 дугаар сарын 18-ны байдлаар манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой ямар нэгэн гомдол, зөрчил, маргаан бүртгэгдээгүй болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



М.ЦОГЗОЛМАА